

Монгол хэлээр

2025-2026

STUDY IN JAPAN

/////// ГАРЫН АВЛАГА ///



ЯПОНЫ ТАЛААРХ 10 БАРИМТ

Япон улсын талаарх үндсэн мэдээлэл

Ойролцоогоор

Газар
нутаг

378,000 км²

Ойролцоогоор

Хүн ам

124,352,000 хүн

Нийслэл

Токио

Мөнгөн
тэмдэгт

Иен (¥)

Японоос төрсөн Нобелийн
шагналтнууд

30 хүн

НҮБ-ын гишүүнчлэлийн
хураамж

3 байр

Үндэсний
нийт бүтээгдэхүүн
(GDP)

3 байр

QS Дэлхийн Их Сургуулиудын
эрэмбэ 2025 ТОП 1000-д орсон
сургуулийн тоо

28 их
сургууль

Үйлдвэрлэлд ашиглагдаж
буй роботын тоо

2 байр

Дэлхийн өвийн тоо

26 газар

Дэлхийн энх тайвны
индекс
(Азидаа)

3 байр

Дэлхийн амьдрахад таатай хот/
сэтгэл татам хотын үзүүлэлт ТОП
10-т орсон хотын тоо

1 Хот
(Токио хот)

Автомашин экспортын
тоо

1 байр

Эх сурвалж: ● Хүүхдийн ГХЯ, "Орчлон дэлхийн эндэв сонин" (<https://www.mofa.go.jp/mofaj/kids/ranking/index.html>) ● Conde Nast Traveler (Readers' Choice Awards 2024)
● Global Peace Index 2024 ● UNESCO World Heritage List (<https://whc.unesco.org/en/list/>) ● Японы роботын аж үйлдвэрийн холбоо (<https://www.jara.jp/data/index.html>)
● Дотоод хэргийн яамны Статистикийн газраас гаргасан мэдээ ● Нобелийн сангийн материал ● Гадаад хэргийн яамны голлох эдийн засгийн үзүүлэлтүүд
● Японы Автомашин Аж Үйлдвэрийн Холбоо ТББ (<https://www.jama.or.jp/statistics/>)

Яагаад Японд сурах ёстой вэ?

Изүмокагура © iki



Японд цайны ёслол, кабуки жүжиг, тулааны урлаг зэрэг уламжлалт соёл болон манга, анимэ зэрэг орчин үеийн соёл зэрэгцэн оршдог.

Өвлийн халуун рашаантай газар. (Гинзан халуун рашаан, Обаназава хот) ©Koichi_Hayakawa

Далай болон уулсаар хүрээлэгдсэн Японд хавар, зун, намар, өвлийн улиралд өөр өөр байгалийн сайхныг тольдох боломжтой.



Соёл



Яхико сүмийн сүмо ордон, ©Yahiko тосгон

Байгаль



Фүжи уул болон Кавагучи нуурын эрэг дээрх намрын нэвчис ©Koichi_Hayakawa

Шинжлэх ухаан & Технологи

Нагиножикан ©yuranii



Хоол

Сүши



Шинкансэн

Дэлхийн жишигт нийцсэн шинжлэх ухаан, технологи нь Японы дэвшилтэт анагаах ухааны салбар болон тав тухтай амьдралын хэв маягийг бий болгож байдаг. Японы засгийн газар шинжлэх ухаан, технологийн салбарын цаашдын хөгжилд ихээхэн анхаарлаа хандуулж байгаа бөгөөд Японд үйлдвэрлэсэн супер компьютерууд дэлхийн шилдгүүдийн тоонд орсоор байна.

ЮНЕСКО-гийн биет бус соёлын өд бүртгэгдсэн япон хоол нь улирлын чанартай баялаг орц найрлагыг шингээсэн эрүүл хоол гэдгээрээ дэлхий дахины анхаарлыг татдаг.




Такояки

Боловсролын тогтолцоо



https://www.studyinjapan.go.jp/ja/search-for-schools/school_search.php



Японд суралцах 7 алхам



START Их сургууль болон мэргэжлийн сургуульд үндсэн оюутнаар элсэх үед



Боловсрол нөхөн олгох бэлтгэл сургалтын талаар

● Боловсрол нөхөн олгох бэлтгэл сургалт гэдэг нь:

Японы их дээд сургуульд элсэн суралцахын тулд 12 жилийн боловсрол эзэмшсэн байх шаардлагатай. Танай улсад бүрэн дунд боловсрол олгох хугацаа 12 жил хүрэхгүй тохиолдолд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас санал болгож буй “Боловсрол нөхөн олгох бэлтгэл сургалт”-ыг төгссөнөөр их сургуульд дэвшин суралцах хүсэлт гаргах эрхтэй болно.

Боловсрол нөхөн олгох бэлтгэл сургалтаар япон хэл сурахаас гадна их сургуульд элсэн ороход шаардлагатай үндсэн хичээлүүдийг суралцах болно. Боловсрол нөхөн олгох сургалт явуулдаг япон хэлний боловсролын байгууллагуудын нэрс Боловсрол, шинжлэх ухааны яамны цахим хуудсанд байдаг.



Боловсрол, шинжлэх ухааны сайдын санал болгож буй боловсрол нөхөн олгох сургалтын төвийн жагсаалт
https://www.mext.go.jp/a_menu/koutou/shikaku/07111314/001.htm



Японы их дээд сургуульд элсэн орох бэлтгэл

EJU шалгалтын талаар



Examination for Japanese University
Admission for International Students (EJU)

Японд суралцагчдад зориулсан шалгалт буюу EJU нь Японы их дээд сургуульд элсэн суралцах хүсэлтэй гадаад оюутнуудын япон хэлний мэдлэг болон суурь мэдлэгийн түвшин (байгалийн ухаан, нийгмийн ухаан, математик) -ийн мэдлэгийг хэмждэг шалгалт юм. Шалгалт өгөх болзол, насны хязгаар байхгүй ба шалгалтын хүчинтэй хугацаа нь 2 жил байна.

Японы их дээд сургуулиудын 60-аас дээш хувь буюу ойролцоогоор 500-аад, үндэсний хэмжээнд бараг бүх их дээд сургуулиуд элсэлтийн сонгон шалгаруулалтад EJU-ын оноог ашигладаг. Түүнчлэн EJU-ын оноог ашиглан Японд ирэхээс өмнө элсэлтийн зөвшөөрөл олгох тогтолцоог нэвтрүүлсэн сургууль, EJU-д өндөр оноо авсан оюутнуудад тэтгэлэг урьдчилан баталгаажуулах тогтолцоо байдгаараа давуу талтай.

※ Элсэлтийн шалгаруулалтад шаардлагатай EJU-ийн онооны хувьд зарим сургууль шалгалт авсан тодорхой он, саруудыг зааж өгдөг тул заавал өөрийн хүсэлт гаргах сургуулийн элсэлтийн журамтай сайтар танилцана уу.



EJU
<https://www.jasso.go.jp/ryugaku/eju/index.html>



Зохион байгуулагдах хугацаа

Жилд 2 удаа зохион байгуулагдана.

		Жилийн эхний шалгалт	Жилийн хоёр дахь шалгалт
1	Шалгалтад бүртгүүлэх	2-3 сар	7 сар
2	Шалгалт өгөх эрхийн бичгээ авах	5 сар	10 сар
3	Шалгалтын хугацаа	6 сар	11 сар
4	Дүн зарлах	7 сар	12 сар

Зохион байгуулагдах газар

Япондоо 17 засаг захиргааны нэгжүүд
Гадаадад 13 улс, бүс нутгийн 17 хот

Гадаадад зохион байгуулагдах улсууд

Энэтхэг (Шинэ Дели), Индонез (Жакарта, Сурабая), Солонгос (Сөүл, Пусан), Шриланк (Колумб), Сингапур, Тайланд (Бангкок, Чиангмай), Тайвань (Тайпэй), Филиппин (Манила), Вьетнам (Ханой, Хо Ши Мин), Хонг Конг, Малайз (Куала-Лумпур), Мьянмар (Янгон), Монгол (Улаанбаатар)

Япон хэл сурах арга

Эх хэл нь япон хэл биш суралцагчдад япон хэлийг заах байгууллагыг ерөнхийд нь 3 том төрөлд хуваадаг.

Япон хэлний сургууль

Сургуулийн үйл ажиллагаа явуулах эрхтэй хуулийн этгээд, эсвэл хувьцаат компани зэрэг байгууллага үүсгэн байгуулсан сургууль юм. Япон хэлний суурь мэдлэг эзэмшүүлэхээс гадна, их дээд сургуульд дэвшин суралцахад бэлтгэх сургалт, бизнесийн япон хэлний сургалт зэрэг олон төрлийн сургалт зохион байгуулдаг. Мөн сургалтын хугацаа нь хэдэн долоо хоногийн богино хугацаанаас эхлээд 2 жил хүртэл үргэлжилдэг сургалтууд ч байдаг.

Хувийн их дээд сургууль, богино хугацааны их сургуулийн гадаад оюутны тусгай анги

Их сургуулийн байгуулсан тусгай анги (тусгай ур чадварын боловсрол олгох зорилгоор байгуулсан хөтөлбөр)-үүд дотор, голчлон гадаад оюутнууд руу чиглэсэн сургалтыг ерөнхийд нь (гадаад оюутнуудад зориулсан тусгай анги) гэж нэрлэдэг.

Гадаад оюутнуудад зориулсан тусгай ангид сувилахуйн тусгай анги, олон улсын тусгай анги, япон хэлний тусгай анги гэх мэт төрөл бүр байдаг бөгөөд сургуулиасаа шалтгаалаад суралцах зүйлс нь өөр өөр боловч, гадаад оюутнуудад зориулсан тусгай ангид ихэнхдээ их сургуульд дэвшин суралцахад шаардлагатай япон хэлний боловсрол, үндсэн суурь хичээлүүд, япон соёлын сургалт гэх мэт хичээлүүд ордог. Сургалтын хугацаа нь 1 жилээс 2 жил хүртэл байдаг.

● Шалгалт авах хичээлүүд

Элсэхийг хүсэж буй сургуулийн шаардлагын дагуу 1–3 хичээл, шалгалт өгөх хэлээ сонгоно.
“Байгалийн ухаан” болон “Нийгмийн ухаан” хоёрыг зэрэг сонгох боломжгүй.

Хичээлүүд	Зорилго	Хугацаа	Шалгалтын оноо	Хичээлийн сонголт	Шалгалт өгөх хэл
Япон хэл	Япон улсын их, дээд сургуульд суралцахад шаардагдах академик япон хэлний чадварыг үнэлэх зорилготой.	125 минут	Уншлага, сонголт, сонголт-уншлага Нийт оноо 0–400 бичгийн хэсэг 0–50 оноо		Зөвхөн япон хэлээр
Суурь мэдлэгийн шалгалт	Байгалийн ухаан	80 минут	0–200 оноо	Физик, хими, биологи гэсэн гурван хичээлээс хоёрыг сонгож өгнө.	Япон эсвэл англи хэлээр өгөх боломжтой
	Нийгмийн ухаан	80 минут	0–200 оноо		
	Математик	80 минут	0–200 оноо	Хичээл-1 Нийгмийн ухааны чиглэл болон математикийн мэдлэг бага шаарддаг байгалийн ухааны чиглэлд зориулагдсан. Хичээл-2 Математикийн хичээлийн мэдлэг өндөр түвшинд шаардагдах мэргэжлүүдэд зориулагдсан. Энэ хоёроос аль нэгийг нь сонгох боломжтой.	

※ Нийгмийн ухааны хичээл нь EJU шалгалтанд хэрэглэгддэг тусгай нэришл бөгөөд Японы ахлах сургуулийн хичээлийн “Иргэний боловсрол (улс төр, эдийн засаг гэх мэт)”, “Газарзүй”, “Түүх”-ийн хичээлүүдийн агуулгыг нэгтгэсэн хичээл юм.

Япон хэл сурах зорилгоос шалтгаалж суралцах хөтөлбөрүүд өөр өөр байдаг.
Тиймээс сургууль сонгохдоо тухайн сургуулийн танилцуулга, мэдээллийг сайтар судалж, өөрийн зорилгод нийцсэн хөтөлбөрийг сонгоорой.

Мэргэжлийн сургуулийн япон хэлний анги

Японы муж бүрийн захирагчийн зөвшөөрлөөр мэргэжлийн сургуулиудад япон хэлний анги байршуулсан байдаг. Зөвхөн япон хэл заахаас гадна их, дээд сургуульд элсэхэд зориулсан бэлтгэл сургалттай байдаг. Сургалтын хугацаа ихэвчлэн 1-2 жил байна.

● Япон хэлний боловсролын байгууллагуудыг хайж олоход дараах вэбсайтууд тус болно.



Япон хэлний боловсролын магадлан итгэлгээтэй байгууллагын мэдээллийн портал
Боловсрол, шинжлэх ухааны яам)
<https://www.nihongokyouiku.mext.go.jp/top>



Япон хэлний боловсролыг дэмжих нийгэмлэг
<https://www.nisshinkyo.org/search>



Хууль зүйн яамнаас зөвшөөрөгдсөн сургуулиудын жагсаалт
https://www.moj.go.jp/isa/applications/resources/nyuukokukanri07_00217.html



Япон хэлний сургуулиудын холбоо (JatLSA)
<https://jalsa.tokyo>





ЗАРДАЛ

Японд сурах зардлаа тооцоолцгооё. Зардал яг хэд вэ?
Тэтгэлэг авах боломжтой юу? Санхүүгийн уян хатан төлөвлөгөөтэй байх нь чухал.

Сургалтын төлбөр болон амьжиргааны зардал

Сургалтын төлбөр

● Их сургуулийн нэг жилийн сургалтын төлбөр (дундаж үнэ)

		Улсын их сургууль	Мужийн их сургууль	Хувийн их сургууль
Бакалавр		535,800 иен	536,191 иен	1,124,476 иен
Магистр	Бакалаврын анги	535,800 иен	536,789 иен	874,054 иен
	Магистрын анги	535,800 иен	536,789 иен	654,325 иен
	Мэргэжлийн зэрэг	535,800 иен	536,789 иен	1,122,969 иен

※ Хувийн их сургуулийн сургалтын төлбөрт барилга байгууламж, тоног төхөөрөмж ашиглалтын зардал багтсан.


Эх сурвалж:

- Хувийн их, дээд сургуульд 2023 онд элсэн орсон оюутнуудын сургалтын төлбөрийн судалгааны үр дүнгийн тухай мэдээлэл
(https://www.mext.go.jp/a_menu/koutou/shinkou/07021403/1412031_00005.htm)
- 2023 оны сургалтын төлбөрийн судалгааны үр дүн (Мужийн их сургууль)
(https://www.mext.go.jp/a_menu/koutou/kouritsu/detail/20240328-ope_dev03-1.pdf)

Амьжиргааны зардал

● Амьжиргааны зардлын тооцоолол

Том хотуудын хувьд амьжиргааны зардал илүү өндөр
Жишээ нь: Токио: 130,000 иен



Эх сурвалж: "Хувийн зардлаар сурч буй гадаад оюутнуудын аж байдлын судалгаа", 2023 он (JASSO)

Оюутны байр 28,000 иен	Хувийн орон сууц 27,048 иен	Будаа (5кг) 3,889 иен
Рамэн 704 иен	Алим (1кг) 849 иен	Кола (1л) 255 иен
Кафены кофе 481 иен	Киноны тасалбар 1,933 иен	Такси (4км) 1,694 иен

Эх сурвалж: Засгийн газрын статистикийн нэгдсэн лавлах. Жижиглэнгийн үнийн судалгаа (Токио хот 2025 оны 1 сар)

※ Нийт мөнгөн дүнг улсын хэмжээнд дундажлан тооцсон.

※ Дотуур байрны төлбөрийг Токиогийн Япон хэлний боловсролын төвийн оюутны дотуур байр, 20 м.кв хувийн сууцны хувьд тооцоолсон болно.

Тэтгэлэг ба санхүүгийн тусламж

Тэтгэлэг
https://www.
studyinjapan.
go.jp/mn/planning/
scholarships/



Арга 1

Засгийн газрын тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргах

*Тэтгэлэгийн төрлөөс хамаараад мөнгөн дүн өөрчлөгдөнө. **Япон хэлний сургуулийн суралцагчдад зориулсан мөнгөн дүн

	Япон Улсын Засгийн газрын тэтгэлэг	Сургалтын урамшууллын тэтгэмж	Гадаадад суралцахад дэмжлэг үзүүлэх систем
Сарын тэтгэлэгийн хэмжээ	117,000 иенээс*	48,000 иен эсвэл 30,000 иен**	80,000 иен
Сургалтын төлбөрөөс чөлөөлөх	✓		
Үнэгүй нислэгийн тийз	✓		
Үнэгүй бэлтгэл хичээл	✓		
Тэтгэлэгийн хугацаа	Суралцаж байх хугацаанд	1 жил болон 6 сар	Гадаадад суралцах хөтөлбөрт хамрагдаж буй хугацаанд
Зорилтот оюутнууд	Магистр, Бакалавр, Техникийн коллеж, Мэргэжлийн сургууль (коллеж), Япон хэл соёл судлаач болон Багшийн мэргэжил дээшлүүлэх курсын оюутнууд	Магистр, Бакалавр, Богино хугацааны дээд сургууль, Техникийн коллеж, Мэргэжлийн сургууль (коллеж), Япон хэлний сургуулийн оюутнууд	Нэг жилээс доош хугацаагаар суралцах, Магистр, Техникийн коллеж, Мэргэжлийн сургууль (коллеж)-ийн оюутнууд
Сурлагын шалгуур	✓	✓	✓
Өрхийн төсөв		✓	✓
Шалгаруулах арга	Бичиг баримтын шалгаруулалт, бичгийн шалгалт, ярилцлага	Сургуулиасаа хамаарна	Бичиг баримтын шалгаруулалт
Сонгогдох хүний тоо	Тодорхойгүй	Ойролцоогоор 7000 орчим хүн	Ойролцоогоор 5000 орчим хүн

Холбоо барих болон бүртгүүлэх бол...

Тухайн улс дахь Японы ЭСЯ/одоо сурч буй сургууль

Сурахаар төлөвлөж буй сургууль

Одоо сурч буй сургууль

Арга 2

Орон нутгийн засаг захиргаа болон хувийн байгууллагуудын тэтгэлэгт бүртгүүлэх

- Сургуульдаа элсэж орсны дараа бүртгүүлнэ.
- Иргэншил, суралцах сургууль, суралцах чиглэлийг ихэнхдээ заасан байдаг.
- Жилд хэдэн ч хүн шалгаруулж болно. Та доорх сайтаас хайлт хийх боломжтой.

Орон нутгийн засаг захиргаа, хувийн байгууллагуудын тэтгэлэг

https://www.studyinjapan.go.jp/ja/planning/scholarships/other-scholarships/



Холбоо барих болон бүртгүүлэх бол...

Гадаадад суралцахаар төлөвлөж буй сургууль/байгууллага

Арга 3

Сургуулийн тусгай тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргах, Сургалтын төлбөрөөс хөнгөлөх болон чөлөөлөх тогтолцоонд хамрагдах

Х их сургуулийн хувьд...

Сургалтын төлбөрөөс чөлөөлөх (50% болон 100%)

Зорилтот бүлэг.....

Санхүүгийн боломжгүйн улмаас сургалтын төлбөрөө төлөхөд хүндрэлтэй байгаа болон сурлагын амжилт сайтай оюутнууд

Ү их сургуулийн хувьд...

Сард 82,000 иений тэтгэлэг (4 жил)

Зорилтот бүлэг.....

Элсэлтийн шалгалтад сайн дүн үзүүлсэн оюутнууд

Холбоо барих болон бүртгүүлэх бол...

Суралцахаар төлөвлөж буй сургууль




АЖИЛ

Японд “Иргэний харьяалал үл харгалзан шилдэг хүний нөөцтэй болох” гэсэн компани, байгууллагууд олширч, гадаад оюутныг ажилд авах нь ихсэж байгаа билээ. Ирээдүйд Японд очиж ажиллацгаая!

Японд ажиллах

Суралцахаас эхлээд ажиллах хүртэл

“Сурах” статусаас ажиллах статус руу өөрчлөлт хийлгэх хүсэлтэд зөвшөөрөл олгосон тоо



Гадаад оюутнуудын ажилд орсон мэргэжлүүд (Эхний 10 байр)

Байр	Ажлын агуулга
1	Орчуулагч, хэлмэрч
2	Мэдээлэл боловсруулах/харилцаа холбооны технологи
3	Төлөвлөлтийн ажил (маркетингийн судалгаа)
4	Захиргаа (хувираа бизнес эрхлэгчээс бусад)
5	Гадаад худалдаа
6	Худалдаа, борлуулалт
7	Төлөвлөлтийн ажил (олон нийттэй харилцах/зар сурталчилгаа)
8	Асаргааны ажил
9	Нягтлан бодох бүртгэлийн ажил
10	Үйлдвэрлэлийн менежмент

Эх сурвалж: “2022 оны Япон дахь гадаад оюутнуудын хөдөлмөр эрхлэлтийн байдал. (Японы цагаачлалын алба)”

Ажилд орохын тулд

Японы ажилд орох үйл явц нь ихээхэн онцлогтой учир ажилд орохыг хүсэж буй оюутнууд эртнээс бэлдэж эхлэх хэрэгтэй. Доорх вебсайт-аас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.



Гадаад оюутны хөдөлмөр эрхлэлтийн талаарх гарын авлага (JASSO)
https://www.jasso.go.jp/ryugaku/after_study_j/job/guide.html

Гадаадын өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийн идэвхтэй оролцоог дэмжих портал (JETRO)
<https://www.jetro.go.jp/hrportal/>



Ярилцлага



Шаардлагатай хүний нөөц болохын тулд япон хэл, Японы байгууллагын соёлыг эзэмшицгээе!

Austin

2012 онд Японд ирээд бэлтгэл сургуулиа дүүргээд Токиогийн их сургуульд улс төр судлалын чиглэлээр элсэн орсон. Одоо чөлөөт програмистаар ажилладаг. Японы их дээд сургуулиуд мэргэжлийн чиглэлээс хамааран цагаа чөлөөтэй зохицуулах, дадлага хийх зэрэг хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох боломжийг олгодог ороо онцлогтой. Түүнчлэн төгсөгчдийг ажилд авах шинэ тогтолцоо бий болж, өндөр хөгжилтэй орнуудын дунд анхны карьераа эхлүүлэхэд хамгийн таатай улс гэж хэлж болно. Японд амжилтад хүрэхийн тулд япончуудтай уусахаас илүүтэй гадаад хүний хувьд өөрийн өвөрмөц давуу талаа ашиглах хэрэгтэй. Японд суралцаж ажилласнаар олж авсан хэлний мэдлэг, өвөрмөц соёлын талаарх ойлголт нь юугаар ч орлуулшгүй давуу тал юм. Даяаршлын эрин үед дэлхийн хаана ч байсан ажиллаж чадах эрэлттэй ажилтан болохыг хүсэж байвал Японд сурч, ажиллахыг зөвлөж байна.



ТҮҮХҮҮД

Би яагаад Япон орныг сонгон суралцах болсон бэ?



Гайхалтай боловсролын орчинд суралцаж байна.

HTET SU

Кобэ электроникийн мэргэжлийн сургууль



Би Японы анимэд татагдан, анимэд бүтээх сонирхолтой болж, бүтээдэг арга техникийг нь сурахаар Японд ирсэн. Одоо Кобэ электроникийн мэргэжлийн сургуульд 3DCG хөдөлгөөнт дүрсийн чиглэлээр сурч байгаадаа маш их баяртай байна. Япон хэлний сургуулиас ялгаатай нь япон оюутнуудтай хамт хичээл үздэг тул эхэн үедээ найзтай болж чадах эсэх зэрэг олон зүйлд санаа зовж байсан. Гэвч олон япон найзтай болж, хамтдаа бүтээл хийж, хөгжилдөн зугаалж, сургуулийн баярт оролцон маш хөгжилтэй оюутны амьдралаар амьдарч байна. Мөн багш нартаа гадаад оюутан гээд ялгаварлан гадуурхагдах явдал огт байхгүй бөгөөд эсрэгээрээ хичээл зүтгэлийг минь үнэлэн, төрөл бүрийн боломж олгодогт чин сэтгэлээсээ талархдаг. Гайхалтай боловсролын орчинд дэмжин тусалдаг багш нар, гайхамшигтай найз нөхдөөр хүрээлүүлэн баяр баясгалан мэдэрдэг.



Оюутны амьдралаараа дамжуулан мэдэрсэн бүс нутгийн сайн сайхан зүйлийг түгээмээр байна.

LEE

Тоттори их сургууль, Анагаах ухааны факультет, хэрэгтээний шинжлэх ухааны тэнхим



Би судлаач болох мөрөөдлөө биелүүлэхээр Японд ирсэн. Япон дахь гадаад оюутны хувьд маш онцгой туршлага хуримтлуулж байна. Миний сурдаг газар нь Япондоо хамгийн хүн ам цөөн Тоттори муж юм. Эхний нэг жил их хэцүү байсан. Тоттори муж нь миний төсөөлж байсан Японоос тэс өөр байсан тул маш их соёлын шокт орсон. Дээр нь нэмээд энд найз нөхөдтэй болоход их хэцүү байсан. Энд амьдрах явцдаа иймэрхүү зүйлстэй нүүр тулж сурах хэрэгтэйгээ ойлгосон. Бүх зүйлс миний хувьд том туршлага болсон. Одоо би Ёнзёма ротари клубийн тэтгэлэг авдаг бөгөөд олон найз нөхөдтэй болсон. Өөрийн гадаад хэлний мэдлэгээ ашиглан муж болон бүс нутгийн хүмүүстэй хамтран энд амьдардаг гадаад хүмүүст туслахаас гадна Тоттори мужийн сайн сайхныг гадны орнуудад түгээж явна гэж боддог.

Оюутны хотхоны амьдрал



Японы хөдөө аж ахуй болон боловсролын системээр дамжуулан дэлхийн хүнсний үйлдвэрлэлд хувь нэмрээ оруулмаар байна.

Arikpo

Тоттори их сургууль, Нэгдсэн хөдөө аж ахуйн судлаачны тэнхим

Дунд сургуулийн сурагч байхдаа сургуулийнхаа сургалт аяллаар Нигерийн хамгийн том газар тариалангийн газарт очсон. Тэнд (аварга том техник) ашиглан тариан талбайд ажиллаж байгаа хүмүүсийг харж биширсэн. Зааварлагч маань газар тариалангийн талаар нарийн тайлбарлаж өгөх үед энэ (аварга том техник) юу болохыг асуухгүй байж чадаагүй. Зааварлагч (энэ Японд үйлдвэрлэсэн трактор) хэмээн урам зоригтойгоор харуулсан. 20 хүн бүтэн нэг өдрийн турш хийх ажлыг трактор нэг цагийн дотор хийдэг болохыг хэлж өгсөн. Үүнд миний сэтгэл их хөдөлсөн. Жил өнгөрөх тусам хөдөө аж ахуйг сонирхох сонирхол маань улам нэмэгдэж, Японд сурах хүсэл тэмүүлэлтэй болсон. Энэ 2 жилд хөдөө аж ахуйн бакалаврын зэрэг авч, одоо докторын зэрэг авахаар зорин Японы хөдөө аж ахуй болон боловсролын системийн олгож буй инновацийн хүрээ, технологийг ашиглан өнөөгийн болон ирээдүйн дэлхийн хүнсний үйлдвэрлэлд хувь нэмрээ оруулахаар бүх чадлаараа хичээж байна.



Миний нэг өдрийн хуваарь

6:30 Босох цаг

Залбирал үйлдсэнийгээ дараа сургууль руугаа явах бэлтгэлээ хийнэ.

15:00 Өдрийн цай

16:00 Судалгаа эсвэл туршилт

8:45 Сургууль руугаа явна

Тухайн өдрийн судалгаа, туршилт хийх төлөвлөгөөгөө боловсруулна.

20:30 Гэртээ харих цаг

Оройн хооллоо ихэнхдээ гэртээ хийнэ. Оройн хоолны дараа Нигери дэх гэр бүлийнхэн болон найз нартайгаа ярилцана.

10:00 Судалгаа хийх, мэдээлэл цуглуулах


Материал унших, өмнөх өдрийн туршилтын үр дүнгээ нэгтгэнэ.

23:30 Залбирлаа үйлдээд, унтаж амарна.



Японд ирж буй гадаад оюутны статистик үзүүлэлт

Оюутнуудыг төрсөн бүс нутгаар нь ангилсан тоо



Улс, бүс нутгаар ангилсан гадаад оюутны тоо

	Улс, (бүс нутаг)-ын нэр	Гадаад оюутны тоо
1	Хятад	123,485 хүн
2	Непал	64,816 хүн
3	Вьетнам	40,323 хүн
4	Мьянмар	16,596 хүн
5	Солонгос	14,579 хүн
6	Шриланк	12,269 хүн
7	Тайвань	7,655 хүн
8	Бангладеш	7,597 хүн
9	Индонез	6,778 хүн
10	Монгол	4,085 хүн

Суралцаж буй шатлалаар ангилсан оюутны тоо

	Гадаад оюутны тоо
Ахисан түвшний сургууль	58,215 хүн
Их дээд сургууль (Бакалавр)	87,421 хүн
Богино хугацааны дээд сургууль	3,265 хүн
Технологийн коллеж	506 хүн
Мэргэжлийн сургууль	76,402 хүн
Боловсрол нөхөн олгох сургалт	3,658 хүн
Япон хэлний боловсролын байгууллага	107,241 хүн
Нийт	336,708 хүн

Эх сурвалж: Японы оюутныг дэмжих байгууллага (Гадаад оюутны элсэн суралцах байдлын талаарх судалгаа) 2024 оны 5 сарын 1-ний өдрийн байдлаар

Зуучлагч байгууллагуудаар дамжуулан Японд суралцах

Өөрөө бие даан Японд суралцахад шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх нь эдийн засгийн хувьд хэмнэлттэйгээс гадна өөрөө шийдвэр гаргах чадвар суух, хэлний мэдлэгээ сайжруулах зэрэг олон давуу талуудтай.

Цаг зав муу, хэлний бэрхшээл зэргээс шалтгаалж зуучлагч байгууллагад хандах сонголт байгаа хэдий ч хэт өндөр зардалтайгаас гадна буруу ташаа мэдээлэл өгдөг байгууллагууд ч байдаг. Тиймээс зуучлагч байгууллагуудад хандах бол сайтар судлахыг зөвлөө.

Зуучлагч байгууллагуудыг сонгохдоо анхаарах зүйлс.....

POINT 1 Төлбөр

- Олон байгууллагыг харьцуулж, зохистой үнэ төлбөртэй байна уу?

POINT 2 Бодит туршлага

- Япон руу илгээсэн оюутны тоо тодорхой хэмжээнд байна уу?

POINT 3 Харилцаа

- Гадаад оюутны зорилгод нийцсэн сургуулийг танилцуулж байна уу?
- Хуурамч бичиг баримтаар хил нэвтрэхийг санал болгож байна уу?
- Асуулт болон бичиг баримт бүрдүүлэлтийн явцын талаар сэтгэлд нийцсэн хариу өгсөн үү?
- Нөгөө талаас өргөдөл гаргахыг яаруулж байна уу?
- Гадаадад сурахын гоё сайхан талуудаас гадна хэцүү талуудыг тайлбарлаж байна уу?

Суралцах хугацаан дахь цагийн ажил

"Сурах" гэсэн оршин суух статустай хүмүүс ойролцоох Гадаадын Иргэн, Харьяатын Газарт "Статусаас гадуур үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл"-ийн хүсэлт өгснөөр **долоо хоногт 28 хүртэл цагаар** ажиллах эрхтэй болдог.

Хувийн зардлаар суралцаж буй оюутнуудын 65% нь цагийн ажил хийдэг бөгөөд 1 сарын дундаж орлого ойролцоогоор 81,000 иен (540 америк доллар) байдаг. Зөвхөн цагийн ажил хийж сургалтын төлбөр болон амьжиргааны зардлаа олох боломжгүй тул цагийн ажилд түшиглэлгүйгээр санхүүгийн төлөвлөгөө гаргацгаая.



"Японд суралцангаа мөнгө хийж болно" гэж тодотгосон зуучлагч байгууллагуудаас болгоомжлох хэрэгтэй.



1 цагт 3,000 иений цалин авах боломжтой.



Цагийн ажлын хөлс нэг цагт 1,300 иен орчим байдаг.

Гадаад оюутнууд цагийн ажил хийгээд сард 300,000 иен олдог.



Цагийн ажил хийгээд сард 81,000 орчим иен олдог.

Японд суралцах тухай мэдээллийн хөтөч

Японд суралцах тухай мэдээллийн хөтөч нь Японд суралцахад бэлдэх, хэрхэн амьдрах талаарх болон мөн тэтгэлэг, их дээд сургуульд суралцахад шаардлагатай бусад мэдээллийг агуулсан болно. Мөн та өөрийн сонирхолд тохирсон сургуулийг мэргэжил, суралцах хэл, сургуулийн байршлаар хайж болно. Японд суралцах сонирхолтой эсвэл Японд суралцах сургууль хайж байгаа, гадаадад сурах тал дээр эргэлзэж байгаа, суралцах улсаа хайж байгаа бол манай Японд суралцах мэдээллийн хөтчөөр заавал зочлоорой!



Японд суралцах тухай
мэдээллийн сайт
<https://www.studyin-japan.go.jp/mn/>



Японд суралцах тухай мэдээллийн яармаг.....

Сургуулийн төлөөлөгчтэй шууд ярилцах ховор боломж юм.
Жил бүр цахимаар болон танхимаар зохион байгуулдаг.
Бид таныг хүлээж байна!
Дэлгэрэнгүй мэдээллийг Японд суралцах тухай мэдээллийн
сайтаас авна уу.

Японд суралцах тухай
мэдээллийн яармаг
<https://www.studyin-japan.go.jp/mn/events/>



JASSO гадаад дахь салбар

JASSO-ийн гадаад дахь 5 төлөөлөгч газар дээр та биечлэн болон утсаар, цахим шуудангаар зөвлөгөө авч, Японд суралцах тухай гарын авлагатай танилцаж болно.



Тайланд

1016/3, 10F Serm-mit Tower, 159 Asok-Montri Rd., Bangkok 10110 THAILAND


Tel : (+66) 2-661-7057
E-mail : info@jeic-bangkok.org
Web : <https://www.jeic-bangkok.org/>
Facebook : <https://www.facebook.com/JASSO.Thailand>
Instagram : <https://www.instagram.com/jasso.thailand/>

702 Garden Tower, 84 Yulgok-ro, Jongno-gu, Seoul 03131 Republic of KOREA

Tel : (+82) 2-765-0141
E-mail : jasso@jasso.or.kr
Web : <https://www.jasso.or.kr/>
Facebook : <https://www.facebook.com/JASSO.Korea>
Instagram : <https://www.instagram.com/jasso.korea/>



Солонгос



Индонез

2nd Floor, Summitmas Tower II, Jalan Jenderal Sudirman Kav. 61-62, Jakarta 12190 INDONESIA

Tel : (+62) 21-252-1912
E-mail : info@jasso.or.id
Web : <https://www.jasso.or.id/>
Facebook : <https://www.facebook.com/jasso.Indonesia/>
Instagram : <https://www.instagram.com/jasso.Indonesia/>
WhatsApp : <https://api.whatsapp.com/send?phone=62212521912>



Вьетнам

4th Floor, CornerStone Building, 16 Phan Chu Trinh, Hoan Kiem, Hanoi, VIETNAM

Tel : (+84) 24-3710-0226
E-mail : info@jasso.org.vn
Web : <https://www.jasso.org.vn>
Facebook : <https://www.facebook.com/JASSO.Vietnam>



Малайз

A-7-5, Northpoint Offices, Mid Valley City, No. 1, Medan Syed Putra Utara, 59200 Kuala Lumpur, Malaysia

Tel : (+60) 3-2287-0812
E-mail : enquiry@studyin-japan.org.my
Web : <https://www.studyin-japan.org.my/>
Facebook : <https://www.facebook.com/JASSO.KL/>

? АСУУЛТ, ХАРИУЛТ

Q. Би Японд дунд сургуульд сурч байсан. Би гадаад иргэдийн элсэлтийн шалгалтад хамрагдах боломжтой юу?

A. Шалгалт өгөх эсэхийг сургууль хянан үзэж шийдвэр гаргана. Японы ахлах сургуулийг төгссөн болон Япон ба өөр улсын хоёр иргэншилтэй хүмүүс гадаад иргэдийн элсэлтийн шалгалтад хамрагдах эсэхээ өргөдөл гаргахаасаа өмнө тухайн сургуультайгаа урьдчилан холбоо барьж, өргөдөл гаргах эрхтэй эсэхээ тодруулаарай.

Q. Магистрт элсэх журам юу вэ?



A. Элсэх боломжтой эсэхийг шалгаж, судалгааны төлөвлөгөө, өргөдлийн бичиг баримтыг сургууль шалгана. Та үндсэндээ удирдах багшаа өөрөө хайж олох хэрэгтэй бөгөөд зарим сургуулиуд өргөдөл гаргахаасаа өмнө багшаасаа урьдчилсан зөвшөөрөл авах шаардлагатай тул багшаа аль болох хурдан олох хэрэгтэй.

Q. Хэзээ өргөдөл гаргах, ямар бичиг баримт бүрдүүлэх, элсэлтийн шалгалтын агуулга юу болохыг хэрхэн мэдэх вэ?



A. Өргөдлийн болон элсэлтийн шалгалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийн вэбсайт эсвэл элсэлтийн гарын авлагаас авах боломжтой. Та элсэх сургуулиа шийдсэнийхээ дараа вэбсайт болон элсэх шалгуурыг аль болох хурдан нягтлаарай.

Q. Ахлах сургуульд суралцах хөтөлбөр, тэтгэлэгт хөтөлбөрийн талаар мэдээлэл өгнө үү.

A. Ахлах сургуульд суралцахад дараах байгууллагууд дэмжлэг үзүүлдэг.

● AFS Intercultural Programs

URL: <https://afs.org/>

※ Find AFS in your country-с өөрийн улсын AFS-ийг хайж олоорой.

● YOUTH FOR UNDERSTANDING

URL: <http://yfu.or.jp>

Японд суралцах нь танд үр өгөөжөө өгнө гэдэгт бид чин сэтгэлээсээ итгэж байна.

Японы оюутныг дэмжих байгууллага (JASSO)-н гадаад оюутныг дэмжих төсөл

- Тэтгэлэг олголт
- Япон улсад хувийн зардлаар суралцах хүсэлтэй гадаад иргэдэд зориулсан шалгалт (EJU)
- Гадаадад суралцах тухай мэдээлэл цуглуулах, түгээх
- Япон хэлний боловсрол
- Орон байрны дэмжлэг

[Хянасан, хэвлэсэн]

Засгийн газрын бие даасан агентлаг Японы Оюутныг Дэмжих Байгууллага (JASSO)

Гадаад оюутны асуудал хариуцсан хэлтэс, гадаадад суралцах мэдээллийн тасаг

〒 135-8630, 2-2-1 Aomi, Koto-ku, Tokyo, Japan

E-mail : infoja@jasso.go.jp

Tel : (+81)3-5520-6111

Web : <https://www.studyinjapan.go.jp/ja/>

Facebook : <https://www.facebook.com/profile.php?id=100092715664950>

Instagram : https://www.instagram.com/jasso_study_in_japan/



Independent Administrative Institution
**Japan Student Services
Organization**

www.studyinjapan.go.jp